



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 4,798,197.00 (дөрвөн сая долоон зуун ерэн найман мянга нэг зуун ерэн долоон) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001749



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн
24 дугаар тогтоолын хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БАЛАНСАД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ төгрөг (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Программ хангамж /Эмэралд 5.0/	2006	ш	1	2,078,196.90	2,078,196.90	2,078,196.90	-
2	Программ хангамж /Виндовс оффис 2010/	2012	ш	4	390,000.00	1,560,000.00	1,560,000.00	-
3	Программ хангамж /Виндовс 7 про 32 бит/	2012	ш	4	290,000.00	1,160,000.00	1,160,000.00	-
Биет бус хөрөнгийн нийт дүн					533,132.99	4,798,197	4,798,197	-
						(дөрвөн сая долоон зуун ерэн найман мянга нэг зуун ерэн долоон төгрөг)		